

Жин Жай Гүн, Фу Жюнь нарын зохиосон толь бичиг ба сурах бичгүүдийн тухайд

САРАНГОЛ (LIU YUE)

ӨМНШУХ-ийн Хэл судлах газрын Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Хураангуй:

Жин Жай гүн, Фу Жюнь эцэг хүү хоёр нь Чин улсын орчуулгын, бичгийн сайд байжээ. "Гурван зүйлийн үг хадмал үзэхүй-д хялбар болгосон бичиг" -ийг Жин Жай гүн голлон найруулсан бол "Монгол тод үсгээр нийлүүлсэн цуглуулга" -ыг Фу Жюнь найруулан зохиожээ. Тус хоёр толь бичиг нь бүтэц агуулгаараа холбоотой бөгөөд манж үсгээр дуудлага хадсан монгол хэлний толь бичиг юм. Үүнээс гадна, Фу Жюнь бас хэд хэдэн сурах бичиг зохиожээ. Түүний дотроос "Анхан сурахын удиртгал" болон "Гурван зүйлийн үсэг хадмал Бичсэн үгний бичиг" хоёроос авч үзэх болно. Тус хоёр сурах бичиг нь дээрх хоёр толь бичигтэй холбоотой бөгөөд цөмөөрөө манж хэлний сурах бичиг болох "Зуун анги"-ийн монгол-хятад хавсаргасан, манж-монгол-хятад хавсаргасан хэлбэр бөгөөд агуулгаараа адил байдаг. Дээрх толь бичиг, сурах бичгүүдийн хоорондын харьцаа холбоог нягтлан үзэхээр дамжуулан, "Гурван зүйлийн үг хадмал үзэхүйд хялбар болгосон бичиг", "Монгол тод үсгээр нийлүүлсэн цуглуулга", "Анхан сурахын удиртгал", "Гурван зүйлийн үсэг хадмал бичсэн үгний бичиг"-үүд нь хоорондоо нягт харьцаатай байж, сүүлийн бүтээл нь өмнөх бүтээлийнхээ үргэлжлэл болон нөхвөр болсон бөгөөд иж бүрэн цуврал бүтээлийн шинжтэй болсон гэдгийг өгүүлсэн юм.

Түлхүүр үг: Жин Жай гүн, Фу Жюнь, толь бичиг, сурах бичиг, харьцаа

Удиртгал

Чин улсын үеийн монгол, манж-монгол хавсаргасан толь бичиг нийт 45 байдгийн дотор дуудлага хадсан монгол хэлний толь бичиг нийт 12 байж, манж-монгол хавсаргасан толь бичгийн 26.7%-ийг эзэлж байдаг. (2018:63) Эдгээр толь бичгүүдийг манж үсгээр хөрвүүлэн бичсэн ба дуудлага хадсан гэж хоёр төрөлд ангилж, дуудлага хадсан толь бичгүүдийг нь манж үсгээр дуудлага хадсан, хятад үсгээр дуудлага хадсан ба манж, хятад, монгол үсгээр харилцан

* © Сарангол 2024

E-mail: sarengaole@163.com

дуудлага хадсан гэх гурван төрөлд ангилан үзэж болно. Манж үсгээр дуудлага хадсан толь бичигт, Жин Жай гүнгийн "Гурван зүйлийн үг хадмал үзэхүй-дүр Хялбар болгосон бичиг" (хойшид "Хялбар болгосон бичиг" гэж нэрлэнэ) болон Фу Жюний "Монгол тод үсгээр нийлүүлсэн цуглуулга" (хойшид "Цуглуулга" гэж нэрлэнэ) хоёр толь бичиг багтан ордог. Эрдэмтэн Цүнх Хуагийн судалгааг үндэслэвэл, Чин улсын үед манж үсгээр дуудлага хадсан олон хэлний толь бичиг нь уг хоёр толь бичиг л байдаг.

Чин улсын үед манж монгол хэлний (буюу монгол хэлний) сурах бичиг нь ихэвчлэн бичгийн хэлний хэл зүйн сурах бичиг болон ярианы хэлний сурах бичиг гэх хоёр хэсэг агуулга багтдаг бөгөөд хэл зүйн бичиг нь хятад хэлээр манж хэлний (буюу монгол хэлний) дагавар, туслах үг, сул үгийг тайлбарладаг бол ярианы хэлний сурах бичиг нь манж хэл (буюу монгол хэл), хятад хэл хавсаргасан хэлбэрийн сурах бичиг билээ. Хятад хэлээр бичгийн хэлний хэл зүйг тайлбарласан сурах бичигт "Дайчин гүрний бүрэн бичиг", "Хялбар болгосон бичиг" гэх зэрэг багтдаг бөгөөд манж хэл (буюу монгол хэл), хятад хэл хавсаргасан ярианы хэлний сурах бичигт "Зуун анги", "Анхан сурахын удиртгал", "Гурван зүйлийн үсэг хадмал бичсэн үгний бичиг" (хойшид "Бичсэн үгний бичиг" гэж нэрлэнэ) зэргүүд багтан ордог.

Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Чин улсын бичгийн сайд Жин Жай гүн (төрсөн, нас барсан он нь тодорхойгүй)-гийн нэр нь Мин Фу, Нийслэлийн Шулуун шар хошууны монгол хүн, Тэнгэр тэтгэгчийн арван гурван он (1748) -ы орчуулах орогсод ажээ. Түүний хүү Фу Жюнь (1749-1834) -ий нэр нь Мэн Цунь болон Сүн Яань, Тэнгэр тэтгэгчийн дөчин дөрөвдүгээр он (1779)-ы орчуулах орогсод, Чин улсын их түшмэл, бичгийн сайд байжээ. Эцэг хүү хоёулаа монгол, манж, хятад хэлийг гарамгай тэгш сайн мэддэг төдийгүй энэ талаар багагүй ном бүтээл бичиж туурвижээ. Тодруулбал "Хялбар болгосон бичиг" (1780), "Анхан сурахын удиртгал" (1794), "Цуглуулга" (1797), "Ховдын засгийн хэргийн бүгд чесе" (1799), "Хялбарчлан ухахуйн товчлол зүйл"(1807), "Бичсэн үгний бичиг" (1830) зэрэг бий. Түүний дотроос Фу Жюний "Анхан сурахын удиртгал", "Цуглуулга", "Бичсэн үгний бичиг" гэх гурван бүтээлийг Жин Жай гүний "Хялбар болгосон бичиг"-тэй харьцуулан тэдгээрийн хоорондох харьцаа холбоог шинжилнэ.

Жин Жай гүн, фу Жюнь хоёрын найруулан зохиосон толь бичиг, сурах бичгүүдийн харьцаа

"Хялбар болгосон бичиг" болон "Цуглуулга" толь бичгийн харьцаа. "Хялбар болгосон бичиг", зохиогч Жин Жай гүн, Фу Жюнь, Тэнгэр тэтгэгчийн дөчин таван он (1780)-д барлан тархаасан, нийт 12 дэвтэр, оршил, хэл зүйн хэсэг, толь бичгийн хэсгээс бүрджээ. Хэл зүйн хэсэгт "Арван хоёр цагаан толгой", "Монгол бичгийн чухал заалт", "Манж бичгийн чухал заалт" зэрэг гурван

хэсэгтэй бөгөөд тэр нь манж, монгол бичгийн зөв бичлэг, хэл зүй ба хийсвэр үгсүүдийг жишээгээр тайлбарласан бол толь бичгийн хэсэг нь нэг нүүрт нийт 8 мөртэй, мөр болгон нь 4 эгнээтэй. Тухайлбал, манж толгой үг, дараа нь хятад орчуулга, түүний дор монгол орчуулга, улмаар түүний дараа манж үсгээр тэмдэглэсэн монгол хадмал орчуулгын бичлэгийн дуудлага. Уг толь бичиг нь манж үсгээр дуудлага хадсан, манж-хятад-монгол гурван хэлний толь бичиг бөгөөд монгол хэлний хэл зүйн сурах бичиг агуулсан байдаг.

"Цуглуулга", зохиогч Фу Жюнь, Сайшаал Ерөөлтийн хоёрдугаар он (1797)-д улаан өнгөөр хуулж бичсэн үсэн бийрийн бичмэл, нийт 8 дэвтэр, оршил, тод үсгийн цагаан толгойн жагсаалт, тод үсгийн текст ба толь бичгийн хэсгээс бүрджээ. Тод үсгийн текст нь тод үсгийн Зуун ангийн 7 хувь үлгэр зохиол юм. Толъ бичгийн хэсэг нь нэг нүүрт 8 мөртэй, мөр болгон нь 5 эгнээтэй. Тухайлбал, монгол толгой үг, дараа нь манж үсгээр тэмдэглэсэн толгой үгийн зөв дуудлага, түүний дор тод үсэг, улмаар түүний дор манж орчуулга, хамгийн дор нь хятад орчуулга зэргээр жагсаасан байдаг. Тус толь бичиг нь манж үсгээр дуудлага хадсан, монгол-тод-манж-хятад дөрвөн зүйлийн үсэгтэй, гурван хэлний толь бичиг бөгөөд тод үсгийн цагаан толгойн жагсаалт, тод үсгийн текст бүхий тод үсгийн хэл зүйн агуулгыг агуулсан байдаг.

"Хялбар болгосон бичиг" нь толь бичгийнхээ монгол хадмал орчуулгын бичлэгийн дуудлагыг манж үсгээр тэмдэглэсэн бол "Цуглуулга" нь толь бичгийнхээ монгол толгой үгийн зөв дуудлагыг манж үсгээр тэмдэглэн хадаж зөв дуудлагыг онцолжээ. Энэ тухай уг хоёр толь бичгийн оршлоос үзье.

"Хялбар болгосон бичиг" нь манж толгой үгтэй манж, хятад, монгол гурван хэлний орчуулгын толь бичиг гэдэг боловч зохиогчоос монгол бичигт дуудлага ялгах дусал бинт байдаггүй тул анх сурах ард дүрс адил дуудлага өөр болон дүрс дуудлага зөрөөтэй үгсийг зөв дуудан танихад хүндрэлтэй байдаг учир тэд нарт монгол бичиг хялбар ухаж эзэмшүүлэх зорилгоо уул толь бичгийн оршилд тодорхой дурдсан байдаг. Оршилд "Монгол бичиг манж бичигтэй адилгүй, манж үсэгт дусал бинттэй тул үсэг бүрийг хялбар танина. Монгол үсэг бол дусал бинтийн ялгаваргүй зарим үсгийг ийн бичээд тийн унших гэж бичээд 'илбэ' хэмээн унших зэрэг болно. Аялгуу (дуудлага) адил боловч үсэг (дүрс) өөр газар (да)-г, (дэ)-г хэмээн бичих тэргүүтэн (зэрэг) буюу, /ялгаа/ байх тулд уншигч, бичигч ард (хүн) ер балрагдмуй (эндүүрэгдэнэ). Үүнд анх монгол бичиг сурах хүнд онц бэрхшээлүгээ... Шугам (мөр) бүрийг дөрвөн өрөө (эгнээ) болгож, оройдоо (эхэнд нь) манж үг, дараа нь хятад үг, нэн дараа монгол үг, дор нь бас монгол үгийг манж үсгээр бичиж гаргаад, мөн монгол үсгийн (тэнгэр)-ийг манж үсгээр хэмээн бичих зэрэг болно. Сурах ард дэвтрийг дэлгэмэгц монгол үсгийн мөн дүрс ба монгол үгний уг санааг хялбар ухтугай, бас монгол үгний хуучин аялгууг (дуудлагыг) мэдтүгэй" (Жин Жай гүн, 1792:1-13) гэжээ. Энд дурдсан "хуучин аялгуу" гэдэг нь монгол хэлний бичлэгийн дуудлагыг нэрлэж байгаа бөгөөд гуравдугаар эгнээний монгол үгийн дор тухайн үгийг дусал бинттэй

манж үсгээр давхар галигласан нь дүрс адил боловч дуудлага өөр үсгүүдийг ялган таних боломжийг бүрдүүлжээ. Ингэснээр бичгийн хэлний дүрсийг хялбар ялган зөв бичүүлэх зорилгодоо ч хүрч чадна.

17 жилийн дараа 1797 онд, Фу Жюнь "Хялбар болгосон бичиг" -ийн суурин дээр, уг толь бичгийн толгой үгийг монгол үгээр солин, тод үсэг нэмэн, монгол толгой үгтэй үсэг дараалсан монгол хэлний анхны толь бичиг болох "Цуглуулга"-ыг найруулан зохиожээ. Зохиогчоос монгол хэлний бичлэг дуудлага зөрөөтэй учир зөв дуудлагыг амаар сургахгүй бол зөв уншин танихад хүндрэлтэй байдаг учир сурах ардад монгол хэлний зөв дуудлагыг хялбар сурч эзэмшүүлэх зорилгоо уул толь бичгийн оршилд тодорхой дурдсан байдаг. Тус толь бичгийн оршилд "Шарагчин гахай жил Фу Жюнь монгол орогсод шалгаж ороод Ёслолын явдлын яамны илүү тэмдэглэгч түшмэл болсны хойно, үргэлж чөлөөтэй бүрийн монгол бичгийн үг нэн олон, байцааж хянахуйнд хялбаргүй хэмээн санагдаж монгол бичгийг мөн цагаан толгойн үсгийн ёсоор жагсаан зохиож бичээд, байцаах хэрэглэхүйд бэлтгэж, гагцхүү монгол бичгийн дотор бас нэг зүйл тод үсэг бий амуй, язгуураас Зүүнгар Өөлд ардын үсэг буюу, бидний улс нь Зүүнгар Өөлдийг төвштгөж тогтоосны хойно нааш цааш үргэлжид бичиг явуулмой, улаан луу жилийн хавар Фу Жюнь зарлигийг дагаж Ховдын Хуувын сайдын хэргийг ялгасны тул, хэрэм хязгаар дув дугуй, хэрэг олонгүй, аймшиггүй үл осолдмой, хэрэг ялгасан чөлөөдөө, мөнхүү тод үсгийг сайхан танигчдыг сурвалжлан эрээд, хамтаар хянан магадалж тод үсгээр орчуулж бичижухуй бас хойч сурагч ард уншихуйяа бэрх хэмээн оройдоо монгол үсэг дараа нь монгол аялгууг дагаж бичсэн манж үсэг бас дараа нь тод үсэг нэн дараа манж үг дор хятад үгийг бичээд шугам бүр таван өрөө болгож зэрэг зэргээр нийлүүлэн магадалж хоёр жилийн хооронд төгсгөжүхуй, лав монгол үсэг дусал бинт үгүй хэрвээ амаар сургахгүй болбоос монгол аялгууг олж үл чадамуй,... " (Фу Жюнь, 1797:1-13) гэжээ. Энд дурдсан "монгол аялгуу" гэдэг нь монгол хэлний зөв дуудлагыг нэрлэж байгаа бөгөөд үүнийг манж үсгээр тэмдэглэн галигласнаар монгол хэлийг зөв уншиж чадах боломжийг бүрдүүлжээ. Мөн Ингэснээр амаар сургах нөхцөл боломж байхгүй үед ч "монгол аялгуу" (зөв дуудлага) -г зөв авиалан уншиж чадуулах болно.




"Хялбар болгосон бичиг" 1792 он,
эхний нүүр



"Цуглуулга" 1797 он, эхний нүүр

Өөрөөр хэлбэл, "Цуглуулга" нь "Хялбар болгосон бичиг"-ийн 3 дугаар эгнээний монгол хадмал орчуулгыг толгой үг болгон солиод түүнд зөв дуудлага (монгол аялгуу) хадан тод үсэг нэмэн, уулын манж-хятад-монгол гурван хэлний толь бичгийг монгол-тод-манж-хятад дөрвөн зүйлийн үсэг бүхий гурван хэлний толь бичиг болгон хөгжүүлсэн бөгөөд "Хялбар болгосон бичиг" нь зөв таньж бичихийг онцолж байсан бол "Цуглуулга" нь зөв таньж уншихыг чухалд үзэх болсон бөгөөд бидний өнөөдрийн монгол хэлний толь бичигт энэ мэтчилэн бичлэгийн галиг болон дуудлагын галиг хадан зөв бичих, зөв уншихыг чухалчилсаар байна. Зургаас харна уу.



“Монгол зөв бичлэгийн толь” 2021 он, эхний нүүр

"Анхан сурахын удиртгал" болон "Хялбар болгосон бичиг"-ийн харьцаа.

"Анхан сурахын удиртгал" нь "Зуун анги"-ийн монгол, хятад хавсаргасан хувилбар бол "Бичсэн үгний бичиг" нь монгол, манж, хятад хавсаргасан хувилбар бөгөөд агуулгаараа адил байдаг. Эх зохиол болох "Зуун анги"-д 2 анги зохиол нэмэн 102 ангитай болгожээ. Тус хоёр ном нь монгол хэлний ярианы сурах бичиг бөгөөд монгол хэлний ярилцааны хэлбэрийн 102 зохиолыг манж үсгээр галиглан тэмдэглэжээ.

Уг хоёр номын манж эх болсон "Зуун анги" бол Чин улсын тэнгэрийн тэтгэсний үед зохиогдлоо гэдэг бөгөөд манж ярианы хэлний сурах бичиг байж ярианы хэлбэрээр бичигдсэн зуун хувь манж хэлний зохиолоор бүрэлджээ. Нийт 4 дэвтэр, модон бар, оршил гаргалгаа байхгүй, зохиогч, сийлэн барласан он жилийн тэмдэглэл ч алга (Курибаяши Хитоши: 2014:44).


Ном нь манж үсгээр бичигдсэн боловч онц зарим хүчир үгсийн хажууд нь хятад орчуулга хадаж, зохиол бүрийн эцэст нь хятад үсгээр дугаарлажээ. Агуулгын хувьд голдуу, манж хэлний суралцлага, бичиг цэргийн эрдмийн

чухалчилгаа, архи өнгөнд шунаж бүрэлгэн сүйтгэхийн цээрлүүлэл, анд нөхрийн холбоо, айл гэрийн амьдрал, ертөнцийн ёс, хүний араншин, өвчин зовлон зэрэг тухайн үеийн манж найман хошууны хүмүүсийн өдөр тутмын амьдралыг тал талаас нь харуулсан байдаг. (Курибаяши Хитоши: 2014:44)

"Анхан сурахын удиртгал" бол "Зуун анги"-ийг монгол хятад хэлэнд орчуулсан, монгол хятад хавсаргасан ярианы хэлний сурах бичиг, нийт 2 дэвтэр, оршил гаргалгаа байхгүй, нэг нүүрт 10 мөр 5 хос монгол хятад хоёр хэлний орчуулга бий. Тэнгэр тэтгэгчийн тавин есөн он (1794) -д Фу Жюний Шао И Тан /紹衣堂/-гаас сийлэн барлажээ. Гадар хавтсанд номын нэр "初學指南"-аас гадна "蒙古語多由口授內地殊難其人因輯是編以便, 初學孤陋寡聞未敢自信惟同志釐正之幸甚" (1794:1) (Монгол хэл нь амаар уламжлан сурдаг, дотор газар мэдэх хүн цөөн учир сурч эзэмших нөхцөл боломж муу, ийм байдалд зориулан найруулвай, сурсан мэдсэн хомсхон тул, мэргэжил нэгтэн эрхэм нөхдийн залруулахыг хүсмүй) гэсэн хоёр өгүүлбэрээр уг сурах бичгийг туурвин зохиох шалтгаан, зорилгоо тушаажээ. Тус бичгийн нэгдүгээр хуудасны хэсэг агуулгаас сийрүүлбэл:

[illegible]

"Анхан сурахын удиртгал" 1794 он



"Бичсэн үгний бичиг" 1830 он

Тухайн үед, монгол хэлний зөв дуудлагыг амаар уламжлан сургадаг боловч зөв уншиж чадах хүн цөөн учир амаар зөв дуудлагыг сургах нөхцөл боломж муутай байсан байдалд зориулан "Анхан сурахын удиртгал"-ыг найруулав гэсэн зорилгыг нь тодхон мэдэж болно.

Тэгвэл "Анхан сурахын удиртгал" нь монгол, хятад хавсаргасан ярианы хэлний сурах бичиг болсны хувьд "Хялбар болгосон бичиг"-тэй ямар харьцаа холбоотой вэ? Чин улсын үед манж, монгол хэлний сурах бичиг нь ихэвчлэн бичгийн хэлний хэл зүйн сурах бичиг болон ярианы хэлний сурах бичиг гэх хоёр хэсэг агуулга багтдаг бөгөөд хэл зүйн бичиг нь хятад хэлээр манж хэлний (буюу монгол хэлний) дагавар, туслах үг, сул үгийг тайлбарладаг бол ярианы хэлний сурах бичиг нь манж хэл (буюу монгол хэл), хятад хэлний хавсаргасан хэлбэрийн сурах бичиг юм. Энэ мэтчилэн "Хялбар болгосон бичиг" дэх "Монгол бичгийн чухал заалт" гэдэг хэл зүйн хэсэгт монгол хэлний нэрийн тийн ялгал, хамаатуулах, олон тооны ай ба жинхэнэ үйл үгийн хэлбэр, нөхцөл үйл үгийн хэлбэр, тэмдэг үйлийн хэлбэр хийгээд сул үг, холбох үг, дагавар үг, туслах үйл үг, аялга үг зэргийг хятад хэлээр тус тус тайлбарлажээ. Энэ нь үнэн хэрэг дээрээ монгол хэлний бичгийн хэлний хэл зүйн сурах бичиг болсон бол "Анхан сурахын удиртгал" нь монгол, хятад хавсаргасан монгол ярианы хэлний сурах бичиг юм билээ. Иймээс "Анхан сурахын удиртгал" нь "Хялбар болгосон бичиг"-ийн хэл зүйн хэсэг "Монгол бичгийн чухал заалт"-ын үргэлжлэл буюу нөхвөр болсон төдийгүй түүнийг "Хялбар болгосон бичиг"-ийн "Монгол бичиг чухал заалт"-ын хамт нийлүүлэн монгол хэлний сурах бичиг болжээ гэж хэлж болохоор байна.

"Бичсэн үгний бичиг" болон "Цуглуулга" -ын харьцаа. Манж "Зуун анги", монгол хятад хавсаргасан "Зуун анги" болох "Анхан сурахын удиртгал" гараад 36 жил болсны дараа 1830 онд Фу Жюнь 82 настайдаа юунд манж, монгол, хятад хавсаргасан "Зуун анги" болох "Бичсэн үгний бичиг"-ийг найруулан зохиов гэдэг асуулт аяндаа дурдагдана. "Бичсэн үгний бичиг" нь "Зуун анги"-ийн монгол, манж, хятад гурван хэлний ярианы хэлний сурах бичиг, нийт 4 дэвтэр, оршилтой, нэг нүүрт 9 мөр, 3 бүлэг манж ярианы хэл ба монгол, хятад хоёр хэлний орчуулга бий. Монгол ярианы хэл нь "Анхан сурахын удиртгал"-тай адилаар манж үсгээр тэмдэглэсэн ярианы хэлний сурах бичиг ажээ. Төр гэрэлтийн арван он (1830)-д У Юнь Тан /五雲堂/-гаас сийлэн барлажээ. Гадар хавтсанд номын нэр:

ᠠᠨᠬᠠᠨ ᠰᠤᠷᠠᠬᠤ ᠤᠳᠢᠷᠲᠠᠭᠤ ᠠᠨᠭᠠᠨ ᠰᠤᠷᠠᠬᠤ ᠤᠳᠢᠷᠲᠠᠭᠤ

ᠠᠨᠬᠠᠨ ᠰᠤᠷᠠᠬᠤ ᠤᠳᠢᠷᠲᠠᠭᠤ ᠠᠨᠭᠠᠨ ᠰᠤᠷᠠᠬᠤ ᠤᠳᠢᠷᠲᠠᠭᠤ

三合語錄

байхаас гадна, сийлсэн цаг/道光十年新鐫/, барлалын газар/板藏琉璃廠五雲堂/ зэрэг ханз үсгүүд бий. Тус сурах бичгийн оршилд

[illegible]

Энд дурдсан "монгол хар үг" гэдэг нь "монгол хэлний нутгийн аялгуу"-г нэрлэж байхыг түүнтэй харгалзсан манж үг " *ᡤᡠᡨᡤᡠ ᡤᡠᡨᡤᡠ* " ба хятад хэлний " 蒙古土話 " хоёроос амархан мэдэж болно. Учир нь, манж хэлний " *ᡤᡠ* " гэдэг үг нь "газар, орон" гэх утгатай бөгөөд " *ᡤᡠᡨᡤᡠ ᡤᡠᡨᡤᡠ* " хэмээх манж хэлний нэр томьёо нь "монгол газрын үг" байж, тухайн үеийн монгол хэлэнд, "монгол хар үг" гэдэг байсан нь ойлгомжтой. Үүнтэй адилаар хятад хэлний "蒙古土話" гэдэг нэр томьёо нь мөн "монгол газрын үг" юм. Иймээс хааны хүргэн, улсад туслагч Делэгээр нутгийн аялгуу болгон засуулжээ хэмээн ойлгож болно. Бид энэхүү "Монгол хэлний нутгийн аялгуу" нь монгол хэлний аль нутгийн аялгуу болохыг нягтлах хэрэгтэй байна.

"Бичсэн үгний бичиг"-ийн агуулга нь "Анхан сурахын удиртгал"-тай агуулгаараа адил боловч манж үсгээр тэмдэглэн бичсэн монгол ярианы хэлийг нь "Анхан сурахын удиртгал"-ынхтай харьцуулан үзэхэд ялгаа зөрөөтэй зүйл ажиглагдаж байна. Жишээ нь **ᠠᠨᠬᠠᠨ ᠰᠤᠷᠠᠬᠤᠨ ᠤᠳᠢᠷᠲᠠᠭᠤᠯ** гэх зэрэг. Дараах харьцууллаас харна үү.

Анхан сурахын удиртгал :

[illegible]

Бичсэн үгний бичиг :

[illegible]

ᠪᠢᠴᠢᠰᠢᠨ (ᠪᠢᠴᠢ) · ᠤᠮᠭᠣᠯ (ᠤᠮᠭᠣ) · ᠨᠢᠭᠡᠭᠡᠨ (ᠨᠢᠭᠡ) зэрэг үгнээс "Бичсэн үгний бичиг" доторх манж үсгээр галиглан бичсэн монгол ярианы хэл нь ойрад аялгуунд төстэй байхыг мэдэж болно.

Японы эрдэмтэн Курибаяши Хитоши, Өвөр монголын эрдэмтэн С.Цэцэнбатын "Анхан сурахын удиртгал" ба "Гурван зүйлийн үсэг хадмал бичсэн үгний бичиг"-т тэмдэглэсэн манж үсгээр тэмдэглэсэн үгний тухай гэх өгүүллийн дүгнэлтэд "Гурван зүйлийн үсэг хадмал бичсэн үгний бичиг" дэх манж үсгээр тэмдэглэсэн монгол хэл ба "Тод үсгийн зуун анги" ("Цуглуулга"-ын тод үсгээр бичсэн 7 ангийг нэрлэж байна)-ийн тод бичгийн хэлний үгсийн дараалал, үгсийн сан, хэл зүйн дагаврын хэлбэр нь яв цав тохиролцон нийцэж байдаг нягт харьцааг үндэслэж "Тод үсгийн Зуун анги"-д суурилан бичигдлээ гэж үзэж болох мөртлөө "ярианы хэл" гэдэг нь үнэндээ тод бичгийн хэлийг манж үсгээр тэмдэглэсэн учир болох юм гэжээ. (2015:54)

Өнгөрсний судалгаа, "Бичсэн үгний бичиг"-ийн оршил болон агуулгаас үзвэл "Гурван зүйлийн үсэг хадмал бичсэн үгний бичиг" дэх манж үсгээр тэмдэглэсэн монгол хэл нь ойрад аялгуу болох бөгөөд уг бичиг нь манж-ойрад (аялгуу)-хятад хавсаргасан ярианы хэлний сурах бичиг мөн гэж хэлж болохоор байна.


Бас "Гураван зүйлийн үг хадмал үзэхүйд хялбар болгосон бичиг"

ᠠᠨᠬᠠᠨ ᠰᠤᠷᠠᠬᠤ ᠤᠳᠢᠷᠲᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠤᠨᠢᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠤᠨᠢᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠤᠨᠢᠯᠤᠯᠤᠰᠤᠨ, "Монгол тод үсгээр нийлүүлсэн цуглуулга"


ᠤᠨᠢᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠤᠨᠢᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠤᠨᠢᠯᠤᠯᠤᠰᠤᠨ "Гураван зүйлийн үсэг хадмал бичсэн үгний бичиг"

ᠠᠨᠬᠠᠨ ᠰᠤᠷᠠᠬᠤ ᠤᠳᠢᠷᠲᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ ᠤᠨᠢᠯᠤᠯᠤᠰᠤᠨ зэрэг номын нэрүүдээс "үг" гэдэг нь "хэл" ᠤᠨᠢᠯᠤᠯᠤᠰᠤᠨ 言 "болохыг, "үсэг" гэдэг нь "(тод) ᠠᠨᠬᠠᠨ 字 үсэг"-ийг зааж байгааг амархан мэдэж болно. Ийм ч учраас "Бичсэн үгний бичиг" нь монгол хэлний тод үсгийн ярианы хэлний сурах бичиг юм билээ.

Түүнчлэн "Цуглуулга" дахь тод үсгийн текст нь манж хэлний сурах бичиг "Зуун анги" доторх 7 анги зохиолын тод үсгийн орчуулга мөртлөө тод үсгийн цагаан толгойн хэсгийн хамт тод үсгийн бичлэгийн дүрэм, хэл зүйн хэв загвар мөн бөгөөд тод үсгийн зөв дуудлага, хэл зүйн хэв загвар болохуйц сурах бичиг мөн билээ. Мөн түүнчлэн "Бичсэн үгний бичиг" нь манж үсгээр тэмдэглэсэн монгол хэлний ойрад аялгууны сурах бичиг гэж ойлгож болох талтай. Иймээс "Бичсэн үгний бичиг" нь "Цуглуулга" дахь тод үсгийн хэл зүйн хэсэгтэй нийлж, тод үсгийн сурах бичиг болсон гэж үзэж болно. Мөн "Бичсэн үгний бичиг" нь "Цуглуулга"-ын нөхвөр хэмээн ойлгож болно.



“Цуглуулга” 1797 он, тод үсгийн
цагаан толгой



“Цуглуулга” 1797 он, тод үсгийн
текст

Судалгааны үр дүн

Жин Жай гүн, Фу Жюнь хоёрын найруулан туурвисан “Хялбар болгосон бичиг” “Анхан сурахын удиртгал”, “Цуглуулга”, “Бичсэн үгний бичиг” гэх ном бүтээлүүд нь хоорондоо нягт харилцаа холбоотой юм. Тодруулбал “Хялбар болгосон бичиг” нь “Цуглуулга” болон “Анхан сурахын удиртгал”-тай шууд харьцаатай бол “Цуглуулга”, “Бичсэн үгний бичиг” хоёр нь хоорондоо шууд харьцаатай байж “Цуглуулга” болон “Анхан сурахын удиртгал” хоёр нь “Хялбар болгосон бичиг”-ийн үргэлжлэл, нөхвөр болсон бол “Бичсэн үгний бичиг” нь “Цуглуулга”-ын үргэлжлэл, нөхвөр болно. “Хялбар болгосон бичиг” нь Жин Жай гүн, Фу Жюнь хоёрын бичсэн бүтээлүүдийнх нь суурь бүтээл болсон байна.

Дүгнэлт

Эцэст нь дүгнээд хэлэхэд, “Хялбар болгосон бичиг” болон “Анхан сурахын удиртгал” хоёр нь нийлээд монгол хэлний толь бичиг, монгол хэлний сурах бичиг болсон бол “Цуглуулга”, “Бичсэн үгний бичиг” хоёр нь хамтдаа монгол-тод үсгийн толь бичиг, тод үсгийн сурах бичиг болжээ. Иймээс Жин Жай гүн,

Фу Жюнь хоёрын найруулан зохиосон “Хялбар болгосон бичиг”, “Цуглуулга”, “Анхан сурахын удиртгал”, “Бичсэн үгний бичиг”-үүд нь бүтэц агуулгын хувьд хоорондоо нягт харьцаа холбоотой байж, сүүлийн бүтээл нь өмнөх бүтээлийнхээ үргэлжлэл буюу нөхвөр байж, тэдгээр нь үнэндээ монгол хэлний толь бичиг, монгол хэлний сурах бичиг, монгол-тод үсгийн толь бичиг, тод үсгийн сурах бичиг гэхчлэн системтэй, иж бүрэн цуврал бүтээлүүд болсон байна гэж хэлж болохоор байна.

Тайлбар

Харвард их сургуулийн Йэньчин Хүрээлэнгийн номын сан дахь Гурван зүйлийн үг хадмал үзэхүй-д хялбар болгосон бичиг (1792), дугаар ТМО 5805.01 3624-ийг ашиглав.

ӨМӨЗО-ны Багшийн их сургуулийн номын сан дахь Анхан сурахын удиртгал (1794), 215001—дугаар 00613—14-ийг ашиглав.

ӨМӨЗО-НЫ НШУХ-гийн номын сан дахь Гурван зүйлийн үсэг хадмал бичсэн үгний бичиг (1830), дугаар 315401-ийг ашиглав.

Abstract:

JING ZHAI GONG and FU JUN, both father and son were civil servants during the Qing Dynasty, they were Jinshi at that time. According to the literature records, SAN HE BIAN LAN written by JING ZHAI GONG, while the dictionary MENG GU TUO TE HUI JI was written by his son FU JUN. It is found that two dictionaries are Mongolian-Manchu phonetic transcribed ones, and both of them are same in concept and structure, as well. Furthermore, FU JUN not only wrote the dictionary but also published several textbooks at the same time. Among those textbooks, the researcher takes the textbooks Introduction to Beginners and Manchu-Chinese-Mongolian trilingual Textbook as examples to study. Through further study on the two textbooks, the researcher found that Manchu language learners took the two textbooks as main learning tools at that time. The two textbooks are same not only in content but also in editions, each of textbook has Mongolian-Manchu bilingual and Mongolian-Manchu-Chinese trilingual editions.

Therefore, the researcher comes to the conclusion that the dictionary of MENG GU TUO TE HUI JI and textbooks he wrote are extension of dictionary of SAN HE BIAN LAN, meanwhile, those works also serve as a supplementary works of SAN HE BIAN LAN, each work presents the characteristics of a series of works by comparative study on two dictionaries and textbooks.

Ном зүй

Курибаяши, Хитоши., Цэцэнбат, С. (2014). “Анхан сурахын удиртгал” ба “Гурван зүйлийн үсэг хадмал бичсэн үгний бичиг”-т манж үсгээр тэмдэглэсэн монгол үгний тухай. Дундад Улсын Монгол Судлал, VI (42)

: 44. [Kuribayashi, Hitoshi., Siqinbatu, S. Study on the Characteristics of Mongolian Language Written in Manchu Alphabet in the “Beginner’s Guide” and “Sanhe Quotations” Dundad ulsyn mongol sudlal, 2014, VI(42):44]

Фу Жюнь. (1797). Монгол тод үсгээр нийлүүлсэн цуглуулга, Бээжин: Хааны ордны хэвлэлийн хороо. [FUJUN. Mongol tod üsgeer niilüüldegen tsuluulga [HUIJI]. Beijing: The Palace Museum Press. 2020.]

春花. (2018). 清代蒙古语标音词典的发展演变, 西部蒙古论坛, I(46): 63. [Chunhua. Study on the Development and Evolution of Dictionaries with Mongolian Phonetics in the Qing Dynasty. Baruun mongol sudlal, 2018, I(46): 63.]

Цэцэнбат, С. (2015). Монгол тод үсгээр нийлүүлсэн цуглуулга дахь тод үсгийн үлгэрийн тухай, ӨМИС-ийн ЭШБ, I(43): 54. [Siqinbatu, S. Study on the Stories Written in Tote in “HUIJI”. Övör mongolyn ih surguuliin erdem shin-jilgeenii bichig, 2015, I(43): 54.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.